



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 1120

Баян-Овоо

Хязгаарлалт тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Онон, Балж, Баян-Овоо багийн Баруун шувуут, Зүүн Шувуут, Баруун шанд, Зүүн шанд, Асгат, Эрээн толгой, Баянцагаан, Тэнгэлэгийн боом, Баруун бэлчир, Зүүн бэлчир, Өндөр даваа, Зүүн Харгиастай, Шовгор, Маяагт, Баян-Овоо зэрэг газруудад ойн хөнөөлт хортон болох Өрөөсгөл хүр эрвээхэйн голомттой газруудад гэрлэн урхийн аргаар хортон шавьж устгалын тэмцлийн ажлыг 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс 08 дугаар сарын 06-ны хугацаанд зохион байгуулах тул дээрх хугацаанд шөнийн цагаар албан байгууллага, аж ахуй нэгж, айл өрхийн гаднах гэрэлтүүлгийг унтраахыг байгууллагын дарга, эрхлэгч, захирал, иргэдэд үүрэг болгосугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хязгаарлалт тогтоосон хугацаанд сумын иргэн, аж ахуй нэгж, байгууллагад мэдээлж, хяналт тавьж ажиллахыг тус Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Д.Батзориг), байгаль хамгаалагч (Ц.Оргил), багийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Гэрэлмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХ-ОД

010000309